



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 02 сарын 08 өдөр

Дугаар A/11

Улаанбаатар хот

Г Дэмжлэг үзүүлэх тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баруун салбарын авто баазын Хог тээврийн машины ачигч Батын Мягмарбаатар, 1 дүгээр хэсгийн Зам талбайн үйлчлэгч Дагвын Хонгорзул нарын амьдралын хүнд нөхцлийг харгалзан үзэж 800 000 /Найман зуун мянган/ төгрөгийн гэрийн эд хогшил худалдан авах дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх хөрөнгийг өөрийн орлогоос тооцон гаргахыг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Ё.Мөнхтуул/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга /М.Зундуйдаваа/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭНХСАЙХАН